

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл өмнөх саруудтай харьцуулахад бага зэрэг нэмэгдсэн, эмнэлгийн хэмжээнд 37 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Үүнээс 7 үйлчлүүлэгч нь 7-с дээш хоног, 21 үйлчлүүлэгч 4-6 хоног амбулаториор үзүүлэхээр тус тус хүлээж байна.

Оношилгооны чиглэлээр MRI, КТГ маш их хүлээгдэлтэй байна. Нийт 649 үйлчлүүлэгч 2-с дээш хоног багажийн шинжилгээ хийлгэхээр хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 200 гаруй үйлчлүүлэгчээр буурсан харагдаж байна./Хүснэгт 1/.

**Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлэгт оношилгоо хийлгэхээр хүлээж
буй үйлчлүүлэгчдийн тоо**

№	Оношилгоо	Хүлээгдэл			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	MRI	30	50	330	410
2	КТГ	108	108	-	216
3	Ходоодны дуран	21	-	-	21
4	Эхо	2			2
	БҮГД	161	158	330	649

Тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааралтайгаар тус эмнэлэгт MRI хийлгэхээр 410 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаагийн дийлэнх буюу 80% нь 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. КТГ хийлгэхээр 216 үйлчлүүлэгч хүлээж байна. MRI шинжилгээ хийлгэх шаардлагатай эмчлүүлэгчийн тоо их байгаа тул 2023 оны цаг тараагдаж дууссан байна.

Тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Ор хүлээж байгаа нийт 771 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сараас 60 гаруй үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 2/.

**Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж,
үйлчилгээний хүлээгдэл.**

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүг д
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Нүд судлал	24	37	53	250	364
2	Чих, хамар, хоолой судлал	11	44	86	114	255
3	Урологи	26	30	20	-	76
4	Хоол боловсруулах эрхтэн судлал	5	10	6	-	21
5	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	5	4	7	-	16
6	Мэс засал судлал	12	-	-	-	12

7	Дотоод шүүрэл судлал	3	6	1	-	10
8	Зүрх судасны эмгэг судлал	1	5	2	1	9
9	Бөөрний эмгэг судлал	2	3	1	-	6
10	Мэдрэл судлал	1	-	1	-	2
	НИЙТ	90	139	177	365	771

Өмнөх саруудын адилаар Нүд судлал, Чих, хамар, хоолой судлал, Урологийн тасагт хэвтэхээр хамгийн их буюу нийт 695 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь нийт орны хүлээгдлийн дийлэнх буюу 90%-ийг эзэлж байлаа. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 88% нь 7-с дээш хоног хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас 70%-иар нэмэгдсэн байна. Нийт 127 үйлчлүүлэгч амбулаторийн 7 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 2-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Мэс засал судлал, Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Мэс засал судлал	3	2	29	34
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	1	27	30
3	Мэдрэл судлал	2	1	15	18
4	Зүрхний эмгэг судлал	14	4	-	18
5	Нүд судлал	1	-	15	16
6	Бөөр судлал	1	-	8	9
7	Эмэгтэйчүүд судлал	1	-	1	2
	НИЙТ	24	8	95	127

Амбулаторийн эмчийн үзлэг хийлгэхээр хүлээж байгаа 127 үйлчлүүлэгчийн дийлэнх буюу 75% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлгийн оношилгооны хүлээгдэл өмнөх сартай ижил түвшинд байна. Нийт 54 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. Үүнд: хэвлийн эхо-д харуулахаар 18, рентген оношилгоо хийлгэхээр 24, MRI оношилгоо хийлгэхээр 12 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна.

Шинжилгээ өгөхөөр нийт 29 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа ба хамгийн олон буюу 19 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ өгөхөөр хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл өмнөх саруудтай адил их байна. Хэвтэж эмчлүүлэхээр нийт 305 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас бага зэрэг буюу 30%-р буурчээ. Хоол боловсруулах эрхтэн судлалын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 192 үйлчлүүлэгч ор хүлээж байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	36	71	85	-	192
2	Мэс засал судлал	10	15	5	-	30
3	Чих, хамар, хоолой судлал	-		8	14	22
4	Уламжлалт эмчилгээ	7	3	8	-	18
5	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	3	4	4	-	11
6	Зүрх судасны эмгэг судлал	3	8	7	-	18
7	Мэдрэл судлал	5	6	-	-	11
8	Уушиг судлал	3	-	-	-	3
	НИЙТ	67	107	117	14	305

Мөн Мэс заслын тасагт хэвтэхээр 30, Чих хамар хоолойн эмчилгээ хийлгэхээр 22 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоног хүлээж байна.

3. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 442 үйлчлүүлэгч 4-с дээш хоногоор хүлээж байгаа нь өмнөх сартай ижил үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 85% /446/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	2	68	70
2	Хөхний төв	2	57	59
3	Толгой, хүзүүний мэс засал	1	51	52
4	Элэг судлал	1	46	47
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	29	16	45
6	Хими	-	45	45
7	Туяа эмчилгээ	-	35	35
8	Ерөнхий мэс засал	16	16	32
9	Ангиографи	-	29	29
10	Зүрх судас судлал	15	4	19
11	Цээжний хөндийн мэс засал судлал	-	5	5
12	Ерөнхий хавдар судлал	2	1	3
13	Хөнгөвчлөх	-	1	1

	Нийт	68	374	442
--	-------------	-----------	------------	------------

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 70, Хөхний төвд үзүүлэхээр 59 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 181 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтэй ойролцоо түвшинд байна. Эход харуулахаар 71, КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 46, хөхний зураг авахуулахаар 21, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 18, ходоод дурандуулахаар 20, рентгенд харуулахаар 4, бүдүүн шулуун гэдэс дурандуулахаар 1 үйлчлүүлэгч 7-с дээш хоног хүлээж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй, нийт 530 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс даруй 130 гаруй үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. /Хүснэгт 6/.

Хүснэгт 6. Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Өдрийн хими	40	63	103	3	209
2	Хими	35	52	81	8	176
3	Ангиографи	6	21	18	2	47
4	Эмэгтэйчүүдийн мэс засал	26	1	7	2	36
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	5	11	13	-	29
6	Өдрийн туяа	3	4	5	1	13
7	Хөнгөвчлөх	-	3	4	1	8
8	Толгой, хүзүүний мэс засал	2	1	1	-	4
9	Ерөнхий мэс засал	2	1	2	1	6
10	Цээжний хөндийн мэс засал	-	1	1	-	2
	Нийт	119	158	235	18	530

Тус эмнэлэгт өдрийн хими эмчилгээ хийлгэхээр нийт 209 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид орж байна. Хүлээгдэл нэмэгдэхэд үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлотт хими эмчилгээ хийдэг нь нөлөөлсөн байна. Хими эмчилгээ хийлгэхээр 176, ангиографиийн тасагт хэвтэхээр 47 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

4. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 125 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Хүзүү, нуруу нугасны кабинетэд үзүүлэхээр 51 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарна./ Хүснэгт 7/

Хүснэгт 7 . Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хүзүү нуруу нугасны кабинет	18	29	4	51
2	Насанд хүрэгсдийн гэмтэл согогын кабинет	15	7	5	27
3	Сэргээн засахын кабинет	3	6	6	15
4	Хүүхдийн гэмтэл согогийн кабинет	7	3	2	12
5	Гар сарвуу нөхөн сэргээх бичил мэс заслын кабинет	5	3	1	9
6	Толгойн мэс засал	2	1	-	3
7	Толгойн мэс засал	2	1	-	3
8	Цээж хэвлийн гэмтлийн кабинет	1	1	-	2
9	Түлэнхий нөхөн сэргээн мэс заслын кабинет	1			
10	Эрүү нүүргийн мэс засал	1	-	-	1
11	Чих, хамар, хоолойн мэс засал	1	-	-	1
	НИЙТ	56	51	18	125

Тус эмнэлэгт MRI оношилгоо хийлгэхээр 225 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 150 гаруй үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ өмнөх саруудын адилаар хүлээгдэлгүй байв.

5. Геронтологийн үндэсний төв

Тус төв нь бусад эмнэлэгтэй харьцуулахад хүлээгдэл бага, дүрс оношилгоо хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байгаа ба бусад тусламж үйлчилгээнд хүлээгдэлгүй байна.

6. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулатори болон лабораторийн тусламж, үйлчилгээ нь өмнөх сарын адилаар хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэхээр 133 үйлчлүүлэгч 3-6 хоног, 171 үйлчлүүлэгч 7-14 хоног, 131 үйлчлүүлэгч 15-30 хоног, нийт 431 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сараас 1.5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

7. Хүрээ амаржих газар

Тус эмнэлэг амбулатори, лаборатори, багажийн шинжилгээ болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлгүй ажиллаж байна.

8. Улсын гуравдугаар төв эмнэлэг, Амгалан, Өргөө АГТМЭ,Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2 болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.